

“Монголын Хүний Хөгжлийн Илтгэл-2007: Монгол улс дахь хөдөлмөр эрхлэлт ба ядуурал” сэдвээр үндэсний хүний хөгжлийн 4 дэх удаагийн илтгэл гарах гэж байгаатай холбогдуулан Их, дээд сургуулиудын оюутнуудын дунд эссэ бичлэгийн уралдаан зарлаж, дүгнэсэн юм. Уралдаан нь “Ажил эрхлэлт ба ядуурал”, “Худалдаа ба ядуурал” гэсэн хоёр сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд нийт 56 оюутан бүтээлээ ирүүлснээс сэдэв тус бүрт тэргүүн байр эзэлсэн 2 оюутны бүтээлийг эрхэм уншигч танд толилуулж байна. Мөн “Хүний Хөгжил” хичээлийн хүрээнд “Ядуусын төлөөх Хөгжил гэж юу?” сэдвээр зохион байгуулагдсан эссэ бичлэгийн уралдаанд түрүүлсэн оюутны ажлыг нийтлэлээ.

Ажил эрхлэлт ба Хүний хөгжил

*Б. Мягмарсүрэн, МУИС-ийн ОУХС,
Олон Улсын Эдийн Засгийн Харилцааны
1-р ангийн оюутан, уралдааны тэргүүн байр*

Би бээр огторгуйн уудамд аялах цэнхэр нүдэн гаригийн зургаан тэрбумын нэг. Бид өнөөдөр мэдлэг, мэдээлэл, технологийн эрин зуунд амьдарч буйгаа мартаж болохгүй. XXI зуунд амьдарч буй хэн ч бай хөгжил дэвшлийн тухай ярихгүй, хэлэлцэхгүй бол хачирхалтай зүйл болох биз. Тэгвэл хөгжлийг та бид хаанаас эхлэх ёстой вэ? Бид яг өөрсдөөсөө эхлэх ёстой. “Амьдралаа авч явж чадахгүй арчаагүй хүмүүсээс болж манай улс хөгжихгүй байна” гэж ярих нэгэнтэй би олонтоо таарч байсан. Тэр хүн яагаад өөрийгөө хөгжүүлэе гэж бодохгүй байгаа хэрнээ бусдыг шүүмжлэхийг урьтал болгож байна вэ? Магадгүй тэр хүн тэдээс арай илүү байж болох л юм. Гэлээ гээд тэднээс л болоод байгаа юм шиг хандана гэдэг утгагүй зүйл. Иймэрхүү хандлага манай нийгэмд нийтлэг болжээ. Энэ нь өнөөгийн зарим залуус өөрсдийн хариуцлагыг бусдад түлхэх сонирхолтой болсныг харуулж байгаа бус уу. Хүний хөгжлийг улс орны хөгжлөөс ангид авч үзэх боломжгүй бөгөөд улсаа хөгжүүлэе гэвэл хүнээ хөгжүүлэх нь зүй ёсны бөгөөд эн тэргүүний асуудал байх болно. Хөгжлийн төв хүн шүү дээ.

1990 оны ардчилсан хувьсгалаас хойш бид ажилгүйдэл гэгч аюулт дайсантай

болж удаа дараа түүнтэй дайн зарласан боловч гутамшигтайгаар ялагдсаар л байна. Хүмүүнлэг хэмээх тодотголтой энэ ардчилсан нийгэм хүн болгоны толгойг илж, идэх хоол, өмсөх хувцсыг нь өгдөг нийгэм биш ч ололтой тал арвинтай билээ. Тухайлбал, бидэнд хөгжих алтан боломжийг ардчилал өгснийг үгүйсгэх аргагүй шүү дээ. Нэгэнтээ л манай нийгэмд ажилгүйдэл байгаа нь илэрхий болохоор та бид нэг л асуудлыг шийдвэрлэх ёстой болж байна. Энэ шаардлага бол өөрийгөө хөгжүүлэх явдал юм. Хэрвээ бид социализмын үед амьдарч байсан бол бидэнд өөрийгөө хөгжүүлэх шаардлага алга. Бидэнд зүгээр л ажлын байрыг өгчих юм чинь. Уг байдал эргээд социализм унах шалтгаан нь болсон гэдгийг бид мэднэ. Хүнээ гайхалтай хөгжүүлж чадаж байгаа Япон улсаас суралцахад юу нь болохгүй байгаа юм бэ? Би яг одоо номын санд суугаад энэхүү эссэг бичиж байна. Энд олон олон аавын хөвгүүд, ээжийн охидууд магадгүй над шиг хөдөөнөөс ирээд, оюутан болчихоод юу ч юм нэг л зүйлийн төлөө толгой өндийлгүй сурах хөдөлмөрт шамдсаар л байна. Юуны төлөө вэ? Ажил, ажил, ажил. Ажилгүйчүүдийн эгнээнд элсэхгүйн л тулд юм. “Ажлын байр” тэд үүнийг л хүсч байна. Тэдэнд өөр юу ч хэрэггүй. Тэднийг

ийнхүү хичээнгүйлэн суралцсных нь төлөө юугаар ч шагнаж болно. Гагцхүү хамгийн том шагнал нь ажлын байр л байх болно гэдгийг би итгэлтэй хэлж чадна. Би сайд дарга биш ердөө л Монголын мянга мянган оюутнуудын нэг нь учир энэ байр суурин дээрээс уг асуудлыг авч үзлээ.

Дөрвөн жилийн дараа сургуулиа төгсөөд, эрдмийн баяраа хийгээд л хөл нь газар хүрэхгүй сэтгэл өндөр гүйцгээнэ. Харин маргааш нь яах вэ? Ажилгүй байна гэдэг амархан мөртлөө аюултай зүйл. *Ажилгүйдэл* Монголын хөгжлийг хүч мэдэн, хөлсөө дуслуулан хойш нь татаж байна шүү дээ. Би хэдийгээр оюутан хүн ч гэлээ ажилгүй, цалингүй байхын горьгч ажилгүй амссан гэж хэлж болно. Учир нь манай гэр бүлд ажилгүй хүмүүсийн тоо жил ирэх тусам өссөөр л, улс орон маань ч ялгаагүй. Жил бүр төгсөн гарч буй шинэхэн төгсөгчид, залуу боловсон хүчнүүдийн маань хэд нь санасандаа хүрсэн цалинтай ажилд орж, амьдралынхаа үзүүрээс

атгаж чадаж байгаа бол доо гэвэл тун ч сэтгэл эмзэглүүлмээр тоо гарах вий. Ингээд л бид амьдралын шигшүүрээр шигшигдэж эхэлнэ. Хэн өөрийгөө хөгжүүлж, хэр чадварлаг мэргэжилтэн болсон байна түүнд л ажлын байр нээлттэй байх болно. Та нэг зүйлийг битгий эндүүрээрээ. Энд би ажлын байр олдох гэж бичээд байгаа боловч үүнийг заавал хэн нэгнээс авах биш харин ч бид өөрсдөө бүтээх асуудлыг хамтад авч үзсэн болно. Ер нь ч тэгээд бид өөрөө өөрсдөдөө цаашилбал, бусдад ажлын байр бий болгож өгч чадах мэргэжилтнүүд болж чадахгүй юм бол 4 жил өөрийн алтан цаг, эцэг эхийн арвин хөрөнгийг, арван сайхан шар үхрийг нь үрэн таран хийждээ гэж ойлгох хэрэгтэй. Миний хувьд энэ байр суурийг хатуу баримталж явдаг. Эндээс үзэхэд бидний хөгжил ирээдүйн бидний ажлын байртай салшгүй холбоотой болох нь харагдаж байна. Өөрийн үзэл бодлыг баримт нотолгоотой болгохын тулд доорх багахан статистик мэдээг орууллаа.

Хүснэгт 1. Хүн амын ажил эрхлэлт, мянган хүнээр

Сонгосон үзүүлэлт	1992	1995	1999	2000	2001	2002	2003	2004
Хөдөлмөрийн насны хүн ам	1134.6	1186.7	1279.3	1374.4	1402.8	1439.2	1488.9	1531.1
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	860.0	812.7	853.4	847.6	872.6	901.7	926.5	950.5
ажиллагчид	806.0	767.6	813.6	809.0	832.3	870.8	926.5	950.5
Бүртгэлтэй ажилгүйчүүд	54.0	45.1	39.8	38.6	40.3	30.9	33.3	35.6
Хүн амын оролцооны түвшин	75.8	68.5	66.7	62.9	62.2	62.7	64.5	64.4
Ажил эрхлэлтийн түвшин	71.0	64.7	63.6	60.0	59.4	60.5	62.2	62.1
Ажилгүйдлийн түвшин	6.3	5.5	4.7	4.6	4.6	3.4	3.5	3.6

Энэ мэдээллээс үзэхэд манай улсын ажилгүйдлийн түвшин тийм ч муу үзүүлэлттэй биш байгаа биз. Та уг мэдээлэлд үнэмшиж байна уу? Би л хувьдаа огтхон ч итгэхгүй байна. Гэхдээ энэ мэдээллийг би баттай эх сурвалжаас олж авсан гэдгээ дурьдая. Ийм бага ажилгүйдэлтэй байсан бол манай улсын хөгжил ямар өндөр байх байсан болоо! Энэ

мэдээлэл үнэнээс хол зөрж байгаа шалтгаан нь байнгын тогтмол орлогогүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй хэрнээ ажил идэвхтэй хайдаггүй, статистикийн албанд бүртгэлгүй хүмүүс юм. Тэгэхээр бид статистикийн үзүүлэлтэнд 100 хувь итгэх аргагүй л байгаа биз дээ.

Дахин хоёр баримт харъя.

Хүснэгт 2. Хүн амын боловсрол эзэмшилт

Боловсрол	1992	1995	1999	2000	2001	2002	2003	2004
Дээд боловсролтой	729	2143	1948	2107	2445	2736	3091	3466
Тусгай дунд боловсролтой	3431	5592	4601	4864	1846	3358	3294	3064
Сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн	12487	10304	9350	9390	11321	3765	3630	3743
Мэргэжилгүй	37395	26668	23868	22209	21425	21018	23320	25281

Мөн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн хүмүүсийн тоо эрс буурсан байгаа биз. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байгаа хүүхдүүд зөв сонголт, зүйтэй алхам хийжээ гэж хэлмээр байна. Алтан гартай ажилчид аль ч нийгэмд, хаана ч эрэлт хэрэгцээтэй, тэднийг гэр бүлдээ нэртэй хүндтэй, нийгэм олондоо хэрэгтэй алдартай хүмүүс болж чадна гэдэгт эргэлзэх хэрэггүй. Эмэгтэйчүүдийн дунд ч ажилгүйдлийн түвшин өндөр байна. Яагаад? Энэ бүхний хариултыг бид хэнээс ч биш өөрсдөөсөө хайх ёстой.

За ингээд би өөрийн гаргахыг зорьсон гол санаагаа бичье. Энэ олон их, дээд сургуулиудад яах гэж суралцаж байгаа юм бэ? бодох л зүйл. Статистик тоо баримтаас харахад жилд дунджаар шинээр бий болж буй ажлын байрны тооноос төгсөгчдийн тоо хол илүү давчихаад байгааг өнөөдөр найман настай балчираас наян настай өтгөс хүртэл мэддэг болжээ. Иймээс бид өнөөдөр өөрсдөдөө ажлын байраа бэлдэх шаардлага тулгарч байна. Яагаад болохгүй гэж? ингэхийн тулд бидэнд хангалттай сайн мэдлэг, манлайлах чадвар, хувийн зохион байгуулалт, цаг төлөвлөлт гээд л бүхий л амьдралдаа хэрэгтэй зүйлсээ өөрөө өөрсдөө хичээл зүтгэлээрээ олж авах нь зайлшгүй асуудал урган гарч ирж байна. Ажил хэрэгч хүнд байвал зохих мэдлэг боловсролыг олж авч гэмээнэ амжилтыг бүтээж чадна. “Ажилгүйчүүдэд хүргэх миний хамгийн том тус бол тэдний нэг болохгүй байх явдал” гэж би боддог. Тиймээс ч би суралцаж буй

шалтгаанаа өөртөө ажлын байрыг бүтээж байна гэж ойлгодгоос биш хэн нэгнээс ажил горьдож бус, бусдын ажлыг булаах төлөө бол бүр ч биш юм. Ажилгүй байгаадаа хэн нэгэнд гоморхож, төр засгаа буруутгаж яваа нэгнийг би ерөөсөө ойлгодоггүй юм. Аливаа ажлыг эхлэх нь түүнийхээ хагасыг нь хийчихлээ гэсэн үг гэдэг шүү дээ. Тиймээс би өөрийгөө зорилгынхоо тэн хагасыг нь биелүүлчихсэн гэж боддог. Хүний хөгжлийн тухай ярихад би нэг зүйлийг дурьдахгүй өнгөрч чадахгүй нь. Өнөө цагт хүн гэдэг амьтан хөгжлийнхөө дээд цэгт хүрэхэд тун ч ойртсон байна. Тиймдээ ч хүн төрөлхтөн эх дэлхийгээ хорь дахин дэлбэлэх боломжтой гайхамшигтай хэрнээ аймшигтай олон арван цөмийн бөмбөгүүдийг бүтээжээ. Хүн төрөлхтөн ийн өөрсдийн эзэмшсэн мэдлэгээрээ бие биенээ 100 хувь баталгаатай хөнөөх агуу хүчирхэг зэвсгийг зохион бүтээжээ. Гагцхүү энд нэг л зүйл байхгүй бол хүн төрөлхтөний өмнө гаталж баршгүй гай зовлон тулгарах болно. Энэ юу вэ гэвэл “сэтгэл”. Сэтгэл зүрхгүй хүнийг хүн гэж яав ч хэлж болохгүй. Ер нь ч тэгээд бусдыг хайрлах сэтгэлээр дүүрэн оюун ухаанд цөмийн бөмбөг биш аюулт өвчнийг эмчлэх эмчийн химийн томъёо л орж ирэх ёстой бус уу? Цөмийн зэвсэг бидэнд юунд хэрэгтэй юм бэ? Юунд ч биш. Гагцхүү зарим нэгэн хомхой санаатны бусармаг хүслийг биелүүлэхэд, нэг нэгнээ айлган дарамтлахад л чиглэгдсэн байдаг. Үүнийг бүтээсэн оюун ухаан ДОХ-ын вирусыг устгаж үгүй хийхэд хүрэхгүй гэж үү. Ингээд бодоход хүн оюун ухаан төдийгүй

сэтгэл, эрүүл бие заавал байх ёстой юм. Аль нэг нь л үгүй бол хоёр хөлтэй тулга шиг байх болно. Өнөөдөр аль ч сайхан өндөр цалинтай ажилд шалгаруулж авахдаа таны мэдлэгийг бус харин таны цээжинд зохилох зүрх чинь эх орны төлөө цохилж байгаа эсэх, та хэр төлөвшилтэй хүн бэ гэдгийг нэгдүгээрт тавьж үздэг болжээ. Тэд таныг өөрсдийн пүүс компанийг нь сүйтгэх *terrorist* байх вий гэж болгоомжилсон хэрэг юм. Мэдлэгээр оюун ухаан нь бялхаж байхад халуун дулаан сэтгэлээр зүрх нь ангаж байдаг хүмүүсийг би "Мэдлэгийн хүйтэн агуулах" гэж нэрлэмээр байна. Ийм хүнийг ердөө ч хөгжилтэй хүн гэж хэлэхгүй. Тэгэхдээ нэг зүйлийг та бид мартаж болохгүй юмаа. "Тэнгэр бурхан хүний дээр хүнийг бий болгоогүй, хүний доор ч хүнийг бүтээгээгүй". Тэр бидэнд тэгш эрхийг өгсөн. Манайд ядуурлын тоо нэмэгдэж, баян ядуугийн ялгаа улам холдсоор л байна. Энэ бүхэн суралцахуйтай л холбоотой. Суралцсанаар л бид хөгжихүйд хүрнэ. Суралцана гэдэг заримдаа биднээс асар их тэвчээр шаарддаг хатуу хөдөлмөр, хэцүү ажил юм. Хэрвээ манай улс эх дэлхий маань дайн дажингүй энх амгалан байвал энэ азтай завшаанаа ашиглаад суралцахад л өөрийгөө зориулж хөгжүүлж авахгүй юм бол хойшид хэзээд дутмаг, ямагт гологдмол нэгэн болоод зогсохгүй ажилгүйчүүдын армид сайн дураараа алба хаах бэлтгэлээ сайтар базааж байгаа хэрэг юм. Бид өнөөдөр хэн бэ гэдгээ харуулж чадахгүй юм бол бусдын хэн болохыг яс махандаа шингэтэл ойлгох ийм л хатуу нийгэмд амьдарч байна.

Эцэст нь, өөрийн дүгнэлтээ бичихэд *ядуурна гэдэг залхуурсны шан* юм. Ажилгүй байна гэдэг өөр хэнээс ч биш танаас л шалтгаалж байдаг. Мөн ажилгүйдэл, ядуурал хоёр ах дүү нар байгаа биз дээ. Гэхдээ би хэзээ ч ирээдүйгээ бараан, бүрхэгээр төсөөлж үзээгүй. Тэгэх ч ёсгүй юм. Бидний зорилго юу вэ гэдгээ цаг ямагт санаж, оргилуун хүсэл мөрөөдлөөр бялхаж явбал амьдарсан шиг амьдарч

ажилласан шиг ажиллаж чадна. Ажил эрхлэлт нь өөрөө биднийг эргээд л хөгжүүлж чадваржуулдаг. Хамгийн гол нь бид бүхнийг өөрсдөөсөө эхэлж бүхний эхлэл болж явах ёстой. Ингэж чадвал бидэнд хөгжлийн гэрэл харагдах болно. Шинэ зуунд амьдрах, шилдэг боловсон хүчин болж Монгол орны хөгжилд хувь нэмрээ оруулж чадна гэдэгтээ би итгэлтэй явдаг. Хүний бусад адгууснаас ялгарах нэг чанар нь мөрөөдөх чадвар юм. Мөрөөдөл бол хүнийг хөгжүүлэх гол хүч мөн боловч мөхөөх ганц зэвсэг бас мөн. Тиймээс бид зорилготой байж зорьсондоо хүрэхийг ямагт тэмүүлж байх ёстой. Тэмүүлэлт өдөр бүр шинэ боломжоор эхэлж шинэ амжилтаар төгсдөг.